

# ТОЙМ

---



**ОЛОН УЛСЫН  
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.11.25

*Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв*

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

2024 он 11-р сарын 25

- АНУ-ын 10-р сарын инфляц 2.6% болж өмнөх сараас өндөр гарлаа.
- ХНС-ийн хүүг бууруулах магадлал буурлааа.
- АНУ-ын ЗГ-ын үр ашигт байдлыг зохицуулах яамны дарга Илон Маск болно.
- БНХАУ-ын эдийн засагт дефляц үргэлжилсээр байна.
- Дефляц нь компанийн ашиг орлогыг багасгахаас гадна эдийн засгийн өсөлтийн дохиог сулруулж, хөрөнгө оруулах идэвхийг бууруулдаг.

Dow Jones	44,2896.51
S&P 500	5,969.30
Nasdaq	19,003.65
DAX	19,322.59
FTSE 100	8,262.08
S&P/ASX 200	8,441.10
HANG SENG	19,132.00

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	0.97%	2.09%	5.18%	17.53%	25.17%	26.93%
S&P 500	0.35%	1.28%	2.78%	25.15%	30.92%	29.92%
Nasdaq	0.16%	1.13%	2.62%	26.60%	33.35%	22.67%

2024 оны 11 сарын 25-ны 11:50

Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	0.92%	0.70%	-0.72%	15.35%	20.54%	26.65%
FTSE 100	1.38%	1.88%	0.16%	6.84%	10.33%	17.29%

2024 оны 11 сарын 25-ны 11:50

Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	0.58%	1.71%	2.81%	11.2%	19.91%	15.98%
Hang Seng	-0.57%	-2.17%	-6.98%	12.35%	9.07%	-20.47%

2024 оны 11 сарын 25-ны 11:50

ЗӨВЛӨМЖ

Биткойны арилжаанд  
оролцохдоо  
АНХААРАХ НЬ:

Хэрэв та Биткойн худалдан авахыг хүсвэл одоогийн дэмжлэгийн түвшинд (\$98,000)-д хэр удаан тогтож буйг ажиглан, 2024 он дуустал үнийн өсөлтийн боломжийг ашиглана үзэх нь зүйтэй. BTC ETF хөрөнгө оруулалт өсч буй нь зах зээлийн тогтвортой байдлыг харуулж байна.



## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### Хөрөнгийн зах зээлийн өсөлт

Өнгөрсөн долоо хоногт гол индексүүд өсөлт үзүүлж, өмнөх долоо хоногийн алдагдлын тодорхой хэсгийг нөхсөн байна. Үүнд Трампын засаг захиргааны бодлогын тодорхойгүй байдал болон Орос, Украины зөрчлөөс үүдэлтэй геополитикийн хурцадмал байдал тодорхой хэмжээний нөлөө үзүүлжээ. Өсөлт нь бүхэлдээ өргөн хүрээтэй байсан бөгөөд жижиг компаниудын индексүүд том компаниудынхаас илүү өсөлттэй байв.

### Nvidia компанийн тайлан

Шинжээчид нэгж хувьцаанд ногдох орлогыг (EPS) 0.74 ам.доллар гэж таамаглаж байсан бол 0.81 ам.доллар байв. Харин борлуулалтын орлогыг 33.2 тэрбум ам.доллар гэж таамаглаж байсан бол 35.1 тэрбум ам.долларт хүрчээ. Ирэх улирлуудад Blackwell чипний эрэлт өндөр байх төлөвтэй байгаа ч үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэх шаардлага тулгарч байна. Долоо хоногийн гүйцэтгэлээр хувьцааны ханшинд өөрчлөлт гарсангүй.


### Хөдөлмөрийн зах зээл болон үл хөдлөхийн салбар

Ажилгүйдлийн тэтгэмжийн хүсэлт хүлээгдэж байснаас бага гарчээ. Шинэ хүсэлт 213,000-д хүрч, өмнөх долоо хоногийнхоос 6,000-гаар буурсан нь 2024 оны 4-р сараас хойших хамгийн бага үзүүлэлт юм. Мөн Үндэсний Үл Хөдлөх Хөрөнгийн Холбоо (NAR)-ны тайлангаар 10-р сард орон сууцны борлуулалт 2021 оны 7-р сараас хойш анх удаа жилийн дүнгээр өссөн нь хөрөнгө оруулагчдын урам зоригийг нэмэгдүүлсэн. Энэ өсөлтөд ажлын байрны нэмэгдэл, тогтвортой эдийн засгийн өсөлт, ипотекийн хүүгийн тогтвортой байдал нөлөөлсөн гэж тайланд дурдсан байна.

### АНУ-ын Үнэт цаас, арилжааны хорооны (SEC) дарга Гари Генслер

Тэрээр 2024 оны 1-р сарын 20-нд албан тушаалаасаа огцрох гэж буйг тус хорооноос албан ёсоор мэдэгдлээ. Ерөнхийлөгчөөр сонгогдсон Трампын томилох шинэ дарга нь Уолл Стрит болон криптовалютын салбарт илүү найрсаг хандлагатай байх магадлалтай гэж шинжээчид үзэж байна. Генслерийн оронд ирэх шинэ дарга SEC-ийн бодлого, чиглэлд томоохон өөрчлөлт оруулах болов уу гэсэн хүлээлттэй байна.

### График 1: АНУ-ын S&P500 индексийн ханшийн таамаглал







## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Хятадын хөрөнгийн зах өмнөх долоо хоногт уналттай байлаа. Шанхайн индекс 1.91%-иар, CSI 300 индекс 2.6%-иар буурсан бол Хонг Конгийн Hang Seng индекс 1.01%-иар унажээ. Энэ нь эдийн засгийн хөнгөн хуваарь, мөн Дональд Трампын засаг захиргаа эхлэхтэй холбоотойгоор хөрөнгө оруулагчдын эрсдэлээс болгоомжлох байдалтай шууд холбоотой.

### Хятад улс бодлогын хүүг хэвээр хадгаллаа

Хятадын банкууд нэг жилийн зээлийн хүүг 3.1%, таван жилийн зээлийн хүүг 3.6% дээр хэвээр үлдээжээ. Аравдугаар сард банкууд хүүг 0.25%-иар бууруулж, зээл авах нөхцөлийг хялбаршуулсан нь ипотекийн болон бусад зээл авахыг хөнгөвчилсөн юм. Энэ удаагийн хүүг хэвээр хадгалсан нь урьдчилан таамаглаж байсан шийдвэр байсан.

### Засгийн газрын арга хэмжээ 2025 оны эхэнд тодорхой болно

Бээжин орон сууцны зах зээлийг сэргээж, хэрэглэгчдийн эрэлтийг нэмэгдүүлэхийн тулд есдүгээр сараас хойш олон төрлийн арга хэмжээ авч эхэлсэн. Ойрын хугацаанд банкуудын нөөцийн шаардлагыг багасгах болон бусад уян хатан бодлого хэрэгжүүлэх төлөвтэй. Гэхдээ шинжээчдийн үзэж буйгаар засгийн газар Дональд Трампын засаг захиргаа ажлаа эхлэсний дараа буюу шинэ оны эхэнд АНУ-ын бодлого тодорхой болсны дараа илүү том шийдвэрүүд гаргаж магадгүй байна.

### Өрийн зохицуулалтын хүрээнд өрийн таазаа нэмж, санхүүгийн ачааллыг буурууллаа

11 дүгээр сарын эхээр Бээжин 10 их наяд юанийн өрийн солилцооны хөтөлбөр хэрэгжүүлснээ зарласан. Энэ нь орон нутгийн засаг захиргааны санхүүгийн ачааллыг бууруулах зорилготой. Мөн 2015 оноос хойш анх удаа орон нутгийн засаг захиргааны өрийн таазыг нэмсэн нь хөрөнгө оруулагчдын анхаарлыг татсан. Гэхдээ энэ арга хэмжээ нь хэрэглээний эрэлт эсвэл борлуулалтыг шууд дэмжихэд чиглээгүй байгаа юм.

### Ажилгүйдэл 17.6 хувиас 17.1 хувьд хүрч буурлаа

Залуучуудын ажилгүйдлийн түвшин хоёр сар дараалан буурч, аравдугаар сард 17.1% болсон нь есдүгээр сарын 17.6%-тай харьцуулахад бага үзүүлэлт юм. Энэ ажилгүйдэл нь 16-24 насны оюутан бус залуусын тоонд хамаарч байгаа бөгөөд энэ нь залуучуудын ажил олголт сайжирч буйг харуулж байна.

### График 2: Hang Seng индексийн ханшийн таамаглал

abliguan published on TradingView.com, Nov 25, 2024 12:10 UTC+8

HSI:HSI, 1D O19,307.34 H19,351.06 L19,102.70 C19,131.82 -98.15 (-0.51%)



# ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН ОНЦЛОХ ТАЙЛАНГУУД

## Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS W WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning November 18, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	Before Open
BITBIT	SYMC	WMT	POWL	NIO	NVDA	BIDU	ESTC	GB	
BIT DIGITAL	Symbotic	Walmart	POWELL	NIO	NVIDIA	Baidu	elastic	Global Blue	
BITDEER	TCCOM	WORKHORSE	THE AZEK COMPANY	TGT	snowflake	Pinduoduo Inc.	ROSS	ADAX	
TWIST	bellring	LOWE'S	KEYSIGHT TECHNOLOGIES	ZIM	paloalto	拼多多	DRESS FOR LESS	adax	
CHANG	tuya	X P E N G	ZIO	TJX	jack	JOHN DEERE	Gap Inc.		
BRIC	AECOM	Medtronic	DOLBY	WIX	CopaAirlines	BI'S	intuit		
BRADY	zenvia	FUTU	danimer scientific	DYCOM	SQM	vestis	Matthews		
MONDEE	VERTICALS	唯品会 vip.com	STAR BULK	WILLIAMS-SONOMA	MAXIMUS	WARNER MUSIC GROUP	NetApp		
CELEBRAR	LAZYS	新海味 weibo.com	KORE	BERRY	BBVA	贝壳	copart		
GOVU		VIKING	LABOY	万物新生 AIR NEW	duostech	爱奇艺	UGI		
		ATOUR GROUP	360 金融	Canaan	CARLYLE	NANOX	NATURAL GROWERS		
http://eps.sh/cal								© 2024 Earnings Whispers	

## Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS W WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning November 25, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	Before Open
BATH & BODY WORKS	ZOOM	ABERCROMBIE & FITCH	DELL	GOOGL				FRONTLINE	
Haidilao	BLUD	KOHL'S	CROWDSTRIKE	GOLDEN OCEAN CRG				MINI	
BIOLINE	FLUENCE	BEST BUY	workday	QUANTASING					
SPLASH	Agilent Technologies	MACY'S	AUTODESK	ARBE					
	WOODWARD	DICK'S SPORTING GOODS	HP	COLPLANT					
	SEMTECH	DURLINGTON	AMBARELLA	HAFNIA					
	AGORA	ANALOG DEVICES	URBAN OUTFITTERS						
	HESAI	TEN LTD	IRIS ENERGY						
	LESLIE'S	UCloudlink	NUTANIX						
	PennantPark								
http://eps.sh/cal								© 2024 Earnings Whispers	